



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨВ ЗҮТГЭЭ!

№100
(100)

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.07.28

МЭНДИЙН ЗУРВАС

Батлан хамгаалах салбарын бие бүрэлдэхүүнд дэлхий дахин, улс орон батлан хамгаалах салбарт өрнөж байгаа мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэх үүднээс эрхлэн гаргаж байгаа "Соёмбо Мэдээ" өдөр тутмын цахим сонин энэ өдөр 100 дахь дугаараараа уншигч тантай уулзаж байна.



Тус "Соёмбо Мэдээ" өдөр тутмын цахим сонин нь Монгол Улсын анхны 5 яамны нэг Батлан хамгаалах яамны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчний 100, Монгол хүн сансарт ниссэний 40 жил, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын түүхт ойг тохиолдуулан 100 жилийн түүхтэй "Соёмбо" редакцын сонин хамт олны зүгээс барьж байгаа бэлэг бөгөөд бид 100 дугаар эрхлэн гаргах хугацаандаа өөрсдийн өнгө төрхөө бүрэн шинэчлэн уншигчийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэйгээр урагшилсаар байна.

булан бүрээс өөрийн анги, нэгтгэл байгууллагын мэдээ мэдээллийг "Цахим шуудан"-аар дамжуулан холын сонин сайхантай учран золгуулдаг БХЯ, ЗХЖШ, нийслэл дүүргийн цэргийн штаб, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл ангийн хэвэл мэдээллийн ажилтан болон соёл хүмүүжлийн офицерууддаа 100 дахь дугаарын баярын мэндийг хүргэе.

"Соёмбо мэдээ" өдөр тутмын цахим сонин энэ л сэтгэлээрээ, энэ л эрчээрээ өглөө бүхний ургах нартай зэрэгцэн Батлан хамгаалах салбарын уншигч та бүхний өглөөний амар мэндийг эрэн мэндчилсээр, мэдээллийн эрин зуунд цаг хугацаатай өрсөн мэдээлэл олж авах, бусдад дамжуулах үүргээ гүйцэтгэсээр байх болно. Мөн Монгол Улсын өнцөг

Бид бүгдийн хамтын ажиллагааны хүрээнд уншигчдад нэг сувагаар мэдээ мэдээллээ хүлээн авах боломж бүрдэж байгааг энд хэлэхэд таатай. Байна. Дахин уншигч танд Өглөөний мэнд хүргэе.

Хурандаа С.ТӨМӨРХУЯГ

ҮЙЛ ЯВДАЛ

КАТАР-МОНГОЛ ХООРОНДЫН БАТЛАН ХАМГААЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ХОРООНЫ ДАРГЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Катар-Монгол хоорондын Батлан хамгаалах, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллах хорооны дарга хурандаа Набел Сороур, энэхүү албан тушаалд 2008 оноос хойш ажилласан бригадын генерал Мохаммед Хассан Ал Тавади нарыг хүлээн авч уулзлаа.

2007 онд "Монгол Улсын Зэвсэгт хүчин, Катар Улсын Зэвсэгт хүчин хоорондын хамтын ажиллагааны гэрээ" байгуулагдсанаар хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа эхэлж өндөр, дунд түвшний харилцан айлчлал, цэргийн

мэргэжлийн боловсон хүчний сургалт бэлтгэл, энхийг дэмжих ажиллагаа, терроризмтэй тэмцэх хамтарсан дадлага, сургууль хийх зэрэг олон чиглэлээр амжилттай хөгжиж байгаад сэтгэл хангалуун байгаагаа талууд нотлов.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр геополитек болон цэрэг, улс төрийн зарим ижил төстэй зүйлс манай хоёр оронд их байдаг бөгөөд хамтын ажиллагааны уламжлалт хэлбэрүүдийг хадгалахын зэрэгцээ шинэ агуулга хэлбэрээр өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана гэдгээ илэрхийлэв.

ХӨГЖИЛ ДЭВШИЛ ТАНЫ ГАРТ

ЭДА-НД ГҮЙЦЭТГЭХ ҮЕДЭЭ БИЕ ДААН ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

ЭДА-нд үүрэг гүйцэтгэж буй хэн нэгнээс асуумаар санагдаг нэг асуулт бий: "Та энэ ажиллагаанд ямар зорилготой ирсэн вэ?" Хариулт бол ихэнх хүмүүсийн хувьд амьдрал ахуйгаа дээшлүүлэх, бас өөрийн нийгэм болон Зэвсэгт Хүчинд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх зорилгоор гэж хариулах байх. Магадгүй цөөн тооны бүрэлдэхүүний хувьд газар үзэх, эсвэл дараа нь үр хүүхэд, хойч үедээ ярих зүйлтэй үлдэх гэх мэт нийтлэг зорилгуудтай байж болох юм.

Тэгвэл энэхүү нийтлэлийн гол зорилго нь эрхэм энхийг сахиулагч та дараагийн нэг зорилгыг өөртөө тавьснаар ажиллагааны хугацааг хэрхэн боломж болгон харж үүнээс давхар юуг олж авч болох вэ? гэдгийг тодорхой хэдэн жишээн дээр үндэслэн танд харуулах явдал юм. Миний бодлоор дээр дурдсан тодорхой нийтлэг зорилгууд нь

утгаа бол таны хайртай бүхнээсээ хол 6 сар, эсвэл 1 жил оршиж буйн үр дүн, шагнал нь юм. Тэгэхээр ЭДА-нд үүрэг гүйцэтгэж байгаагийн хувьд та дээрх зүйлсийг хүссэн хүсээгүй хүртэх эрхтэй хүн болж байгаа юм.

Товчхондоо та ажиллагааны газар оронд нэгэнт ирсэн л бол буцах зам үгүй ба дээрх зорилгууд тэр чигтээ биелэх нь гарцаагүй. Тэгэхээр нэгэнт биелэх нь тодорхой зорилгын талаар бүтэн жил бодоод суух нь мэдээж утгагүй учраас нэмэлт зорилго өвөрлөх хэрэгцээ шаардлага гарч байна гэсэн үг. /Жич: миний бичиж буй зүйлс зөвхөн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаанд бидэнд олддог "чөлөөт цаг"-аар хийх зүйлсийн тухай гэдгийг анхаараарай./

Тэгвэл бидний зорьж, хэрэгжүүлж болох нийтлэг зүйлс юу байж болох вэ? /үргэлжлэл нь арын нүүрт/



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 157.974 +1249	ЭДГЭРСЭН 154.172 +2014	НАС БАРСАН 782 +8
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4012 +71	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 262 +14	ЭДГЭРСЭН 3677 +32
-----------------------------	--------------------------------	----------------------

ӨДӨРТӨӨ 24-26 ГРАДУС ДУЛААН БАЙНА

Малчид, иргэдийн анхааралд: Нутгийн зарим газраар бороо, дуу цахилгаантай аадар бороо орох тул мөндөр, нөөлөг салхи, аянга цахилгаан, үер усны аюулаас сэрэмжтэй байхыг анхааруулж байна.

07 дугаар сарын 28-ны 20 цаг хүртэлх цаг агаарын урьдчилсан мэдээ:

Хур тунадас: Нутгийн төв хэсгээр үүлшинэ. Бусад нутгаар солигдмол үүлтэй. Шөнөдөө баруун аймгуудын нутгийн хойд, говийн аймгуудын нутгийн баруун хэсэг, төвийн аймгуудын нутгийн зарим газраар бороо, дуу цахилгаантай аадар бороо орно.

Салхи: Ихэнх нутгаар баруун өмнөөс секундэд 5-10 метр, нутгийн зарим газраар борооны өмнө түр зуур ширүүснэ

Агаарын температур: Монгол-Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг, Завхан голын эх, Хүрэнбэлчир орчим, Тэрэлж голын хөндийгөөр

шөнөдөө 5-10 градус, өдөртөө 19-24 градус, Их нууруудын хотгор, Хангайн нурууны өвөр бэл болон говийн бүс нутгийн баруун өмнөд хэсгээр шөнөдөө 17-22 градус, өдөртөө 29-34 градус, бусад нутгаар шөнөдөө 11-16 градус, өдөртөө 23-28 градус дулаан байна.

УЛААНБААТАР ХОТ ОРЧМООР: Үүлшинэ. Шөнөдөө бороо орохгүй, өдөртөө дуу цахилгаантай бага зэргийн аадар бороо орно. Салхи баруун өмнөөс секундэд 5-10 метр. Шөнөдөө 14-16 градус, өдөртөө 24-26 градус дулаан байна.

БАГАНУУР ОРЧМООР: Үүлшинэ. Шөнөдөө бороо орохгүй, өдөртөө дуу цахилгаантай бага зэргийн аадар бороо орно. Салхи баруун өмнөөс секундэд 6-11 метр. Шөнөдөө 10-12 градус, өдөртөө 23-25 градус дулаан байна.

ТЭРЭЛЖ ОРЧМООР: Үүлшинэ. Шөнөдөө бороо орохгүй, өдөртөө дуу цахилгаантай бага зэргийн аадар бороо орно. Салхи баруун өмнөөс секундэд 5-10 метр. Шөнөдөө 8-10 градус, өдөртөө 22-24 градус дулаан байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	🌧️ 12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.847.0	2.850.0
EUR 🇪🇺	3.365.0	3.375.0
CNY 🇨🇳	439.5	441.2
RUB 🇷🇺	39.10	39.70
JPY 🇯🇵	25.45	26.02
KRW 🇰🇷	2.38	2.52

ЗУРХАЙ

2021.07.28 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 23/

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САР. ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна
Наран ургах, шингэх:
05:24-20:38

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал:

Шороо

Аргын тооллын 7 дугаар сарын 28. Билгийн тооллын 20. Буд гараг.

Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба тогой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, лусыг тахих, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, сэтгэлд сэтгэж газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал "Сайн нөхөртэй учирах" хэмээх сайн.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 195,310,474
Эдгэрсэн Нийт: 177,102,067
Нас барсан Нийт: 4,181,982

ДЕЛЬТА ХУВИЛБАР АНХЛАРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

- Суулгах
- Хамар битүүрх, нус гоожих
- Булчин өвдөх
- Урт хугацаагаар толгой өвдөх
- Бөөлжих
- Хоолой өвдөх
- Бие тавгуйрх, идэрх

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРӨЙ.

СПОРТ



Хүн төрөлхтний баяр цэнгэл ТОКИО-2020 Олимпын XXXII наадам энэ сарын 23-нд эхлээд байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэрийн өмнөөс тус наадамд спортын 7 төрлөөр 12 тамирчин эрх аван оролцож байна.

Тус наадамд Монгол Улс оролцож эхэлснээс хойш Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны тамирчид тасралтгүй оролцсон байдаг бөгөөд Олимпын наадмын мөнгө, хүрэл, шагналт байрыг нийт 13 тамирчин хүртсэн байна. Зэвсэгт хүчний төлөөлөл нийт тамирчин дайчиддаа амжилтын дээдийг хүсэн ерөөе.

ӨНӨӨДӨР МАНАЙ УЛСЫН 5 ТАМИРЧИН СПОРТЫН ГУРВАН ТӨРӨЛД ӨРСӨЛДӨНӨ



10:00. Жүдо бөхийн эрэгтэйчүүдийн -90 кг жинд Г.Алтанбагана зодоглоно. Тэрээр дэвжээний хоёр дахь барилдааныг дэлхийн хошой аварга Испанийн Николоз Шеразадишвилитэй хийнэ. 10:30. Боксын эмэгтэйчүүдийн -75 кг жингийн эхний шатанд М.Мягмаржаргал 2019 оны дэлхийн аварга Их Британийн

Лорен Прайстай тоглоно. 12:50. Байт харвааны эмэгтэйчүүдийн ганцаарчилсан төрлийн шигшээ 32-т Б.Урантунгалаг Японы Азуса Ямаүчитэй цэц сорино. Хэрэв ялбал үргэлжлүүлэн шигшээ 16-д өрсөлдөнө. 16:18. Байт харвааны эрэгтэйчүүдийн ганцаарчилсан төрлийн

шигшээ 32-т Б.Отгонболд Хятадын Жиалун Литэй цэц сорино. Хэрэв ялбал үргэлжлүүлэн шигшээ 16-д өрсөлдөнө. 18:06. Боксын эрэгтэйчүүдийн -57 кг жингийн шигшээ 16-д Э.Цэндбаатар Вьетнамын Нгуен ван Дуонтой тоглоно. Тэрээр эхний шатанд Кенийн боксчныг ялсан билээ.

/Гүрүүч эхний нүүрт/

Гадаад хэл:
Таны хувьд офицер ахлагч гээд хэн байхаас үл хамааран ирээдүйд англи хэлний дамжаанд суралцах боломж гарах нь тодорхой. Харин та тэрхүү боломжид өөрийгөө хэр бэлтгэсэн байх вэ гэдэг л хамгийн чухал асуудал. Миний хувьд сүүлийн 6 жилийн хугацаанд англи хэлний багшаар ажиллаж байгаагийн хувьд нэг зүйлийг өдөр тутамдаа анзаардаг. Энэ нь юу вэ гэхлээр англи хэлний дамжаанд суралцаж буй бүрэлдэхүүн маань ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаандаа англи хэлний дамжаанд хэрэглэгдэх шинэ үгсийг цээжлээд ирсэн бол энд сурах хугацаанд ямар их хөрөнгө оруулалт байж болох вэ гэсэн "Харамсал" юм. Яагаад вэ гэхлээр англи хэлний дамжаанд өдөр тутамдаа багадаа 40 шинэ үг цээжлэх хэрэгцээ гардаг. Харин үүнийг урьдчилгаад цээжилчихсэн хүн энэ дамжаанд суралцвал ачаа нь хэрхэн

хөнгөлөгдөх нь ойлгомжтой байх. Харин үүнийг яаж хийх вэ? Хариулт нь их энгийн: Зэвсэгт Хүчний Гадаад Хэлний Сургалтын төвөөс эрхлэн гаргасан англи хэлний дамжааны үед хэрэглэгдэх шинэ үгийн англи монгол орчуулгатай гарын авлага бий. Үүнээс багадаа эхний 10 номын үгийг маш сайн цээжилсэн байхад л болно. Харин нэг анхаарах зүйл нь дуудлагыг анхнаас нь зөв цээжлэх ёстой бөгөөд энэ тал дээр өмнө нь дамжаанд суралцсан цэргийн багынхаа хэн нэгнээс тусламж авахад л болно. Мөн эцэст нь гадаад хэл бидний ажил амьдралд ямар чухал шаардлагатай байгаа гэдгийг та надаар хэлүүлэлтгүй олон жишээн дээрээс харж байгаа байх.

Өөрийн хүсдэг, сонирхдог зүйлс дээрээ ажиллах:
Хүн бүхэнд л өөрийн хүсдэг, сонирхдог, өөрийн хобби гэж хэлж болох зүйлс бий. Харин ЭДА-нд үүрэг гүйцэтгэх хугацаа нь бидэнд энэхүү өөрийн сонирхлоо хөгжүүлэх,

цаашлаад мэргэжлийн түвшинд хүргэхэд хамгийн тохиромжтой үе гэдгийн онцолмоор байна. Таны сонирхол бялдаржуулах урлагаар хичээллэх, хөгжмийн зэмсгүүд тоглож сурах, эсвэл гар урлал, гээд юу ч байж болох ба хамгийн чухал нь тэдгээр нь юу ч байлаа гэсэн энэ хугацаанд хангалттай сайжруулах боломж бий гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй. Мөн хүн гэдэг сонирхолтой зүйлдээ цуцалтгүй, шаргуу ажиллаж чаддаг ба үүгээрээ маш том амжилт гаргах боломж бусад зүйлстэй харьцуулахад хувь илүү гэдгийг хэлмээр байна. Таны хийхийг хүсэж буй зүйл нь дээр дурдсанаас аль нь ч байлаа, бүр эсвэл тэс өөр зүйл байсан ч гэсэн ЭДА-ны хугацаанд тухайн зүйл дээрээ төвлөрч ажилласнаар бидний хамгийн их хүсэн хүлээдэг эх оронруугаа нисэх хугацааг бидэнд гайхалтай хурдан авч ирнэ гэдгийг сануулахыг хүсэж байна.

/үргэлжлэл бий/
Ахлах ахлагч Ц.Батболд

ДЭЛХИЙД

ХЯТАДЫН МУЖУУДАД "COVID-19"-ИЙН ХАЛДВАР ДАХИН БҮРТГЭГДЭЖ ЭХЭЛЛЭЭ



Хятад улсад энэ долдугаар сарын 25-ны өдөр "Covid-19"-ийн 76 тохиолдлыг бүртгэсэн нь нэгдүгээр сараас хойшхи хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Тус улс халдвартай тэмцэх бодлогынхоо хүрээнд бүх нийтийг шинжилгээнд хамруулах, халдварын тохиолдол бүрийг илрүүлэх зэрэг арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж ирсэн. Гэвч сүүлийн өдрүүдэд орон нутгуудад халдварын тархалт эргэн нэмэгдэх төлөвтэй байгаа юм. Тус улсын Эрүүл мэндийн үндэсний комисс "Орон нутгийн халдварын

тоо өмнөх өдөр 5 байсан бол өнөөдөр 40 болж өслөө" гэж Даваа гаригт мэдэгдсэн. Тухайлбал, өнгөрсөн долоо хоногоос халдвар гарч эхэлсэн Наньжин хотод долдугаар сарын 25-ны өдөр нийт 75 тохиолдол бүртгэгдсэн нь хамгийн дээд үзүүлэлт байв. Тиймээс тус хотын захиргаа такси, машин зэрэг авто тээврийн хэрэгслийг хотоос гарахыг хориглож, холын замын тээвэр эрхэлдэг найман автобус цэгийн үйлчилгээг түр зогсоож, бүх нийтийг шинжилгээнд хамруулах аяныг эхлүүлжээ. Тус хотын захиргаа хоёр дахь удаагийн

бүх нийтийн шинжилгээг эхлүүлсэн гэдгээ өнгөрсөн Ням гаригт мэдэгдсэн бөгөөд нийт 9.3 сая оршин суугчдыг хамруулаад байгаа аж. Хятадад шинж тэмдэггүй тохилдлууд мөн нэмэгдсээр байгаа бөгөөд өчигдөр 17, өнөөдөр 24 тохиолдол бүртгэгджээ. Үүнээс дөрвөн тохиолдол нь Жянсу, Гуандун, Аньхуй, Сычуань зэрэг орон нутгийн мужуудад тус тус илэрсэн байна. Хятадад "Covid-19"-ийн халдвар анх гарсанаас хойш нийт батлагдсан тохиолдол 92605 болж, нас барсан хүний тоо 4636 байна.

ЦАГ ҮЕ

ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ СЭТГЭЛ ЗҮЙЧИД МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРАГДАЖ ЭХЭЛЛЭЭ

2021-2022 оны хичээлийн жилд 30 сэтгэл зүйчийг ерөнхий боловсролын сургуульд ажиллуулахаар сонгон шалгаруулалтыг хийгээд байна. Эхний ээлжинд "Тогтвортой хөгжлийн боловсрол II" төслийн түшиц 30 сургуулийг сонгосон бол хоёр дахь ээлжид 45 сургуулийг нэмэхээр төлөвлөөд байна. Сонгосон сэтгэл зүйчдийг хүүхэдтэй

ажиллах чиглэлээр мэргэшүүлэх 45 хоногийн сургалт энэ 7 хоногт эхэлсэн юм. БШУЯ, НҮБ-ын хүүхдийн сан хамтарч 2020 онд хийсэн судалгаанаас харахад сурагчдын 67,8 хувь нь ганцаардсан 59 хувь нь бухимдалтай 42,4 хувь нь айдас зовнилттой 56,2 хувь нь дасан зохицох чадвар сул байсан

юм. Дээр дурьдсан асуудал нь өсвөр насны хүүхдүүдийн харилцаа хандлага, итгэл үнэмшил, өөрийн үнэлэмж, сурлагын амжилт зэрэгт сөргөөр нөлөөлж байна. Цаашилбал насанд хүрсэн хойноо ч үргэлжлэх магадлалтай байгаа юм. Тиймээс өсвөр насны хүүхдүүдэд чиглэсэн тусламж үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байна.

ТОКИО 2020 УРИАЛГА

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн ахлах ахлагч, Үндэсний шигшээ багийн тамирчин, хөнгөн атлетикийн марафон гүйлтийн олон улсын хэмжээний мастер Цэвэррагдангийн Бямбажав Японы Кириширо аймгийн Ойтад 2020 оны хоёрдугаар сарын 2-нд болсон 64 дэх удаатгийн уламжлалт "Беппу-Ойта" олон улсын марафонд хүрд хрээ сорин уралдаж, 2 цаг 09 минут 05 секундн амжилтаар V байр зураг "ТОКИО-2020" зуны олимпын 32 дугаар наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцох эрхээ аваад байгаа билээ. Ахлах ахлагч Ц.Бямбажав цэргийн хрний тэсвэр хатуужил, бие бялдрын өндөр бэлтгэлжилт, хүрд хрчийг харуулаж, эх орон, Зэвсэгт хүчин, Агаарын цэргийн алдар хрндийг тийв, дэлхийд цугурайтлуулах зорилго тэмцэрлэлтэйгээр бэлтгэл сургуулилтаа амжилттай базааж, ирэх сарын 2-ны өдөр эх орноосоо мордох гэж байна. Үйлд ахлах ахлагч Ц.Бямбажавыг "ТОКИО-2020" зуны олимпын 32 дугаар наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцох шаардлагатай санхржилтийг нь брдррлах хрээнд "Этгээлийн дэмжлэг" хандив өргөхийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн нийт бие бррэлдхрнрээ уриалж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ ХОШУУЧ ГЕНЕРАЛ О.ЭНХБАЯР

Улаанбаатар хот
2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр